

ДҮРМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрхэм хүндэт Үнэлгээчид, Институтын гишүүд ээ !!!

ММҮИ-ийн Бүх гишүүдийн 3-р хурлыг бид 6-р сарын 16-ны өдөр хийх гэж байгаа билээ. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батлах асуудлуудын нэг нь Институтын дүрмийн өөрчлөлт юм. Өмнөх 4 жилд дүрмийг мөрдөж ажиллах явцад ажиглагдсан дутагдалтай талууд, Үнэлгээний Олон Улсын Стандартын Консулын албан ёсны гишүүн болсноор Мэргэжлийн байгууллагад тавигддаг шаардлага зэргийг харгалзан дүрэмд зарчмын хэд хэдэн өөрчлөлтийг оруулахаар төслийг боловсруулан хүргүүлж байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдсон Ажлын хэсгээр хэд хэдэн удаа хэлэлцэн Инстиутийн дүрмийн өөрчлөлт, Мэргэшсэн Үнэлгээчдийн Ёс зүйн дүрмийн өөрчлөлтийг боловсруулан бүх гишүүдэд хүргүүлж байна.

Уг дүрмийн өөрчлөлтөөр 29 заалтыг дахин найруулж, 2 заалтыг хасах, 4 заалтыг нэмж тусгахаар боловсруулсан.

Дүрмийн өөрчлөлтөөр зарчмын дараахь асуудлуудыг оруулсан. Үүнд:

1. Институтийн бүтцийн Удирдах Зөвлөлийг 13 хүнтэй байсныг 15 болгож нэмэгдүүлэх, 4 хороотой байсныг 5 болгон үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын хуваарилалтыг жигдрүүлэх бодлогыг баримталсан, Нэмэгдсэн хороо нь гишүүдийн судалгаа, бүртгэл, нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг бүртгэх, гишүүдийн үүргийн биелэлтийг хянах чиг үүрэг бүхий Гишүүнчлэл-Нэр дэвшүүлэх хороо байна;
2. Гишүүдийн сонгох, сонгогдох, гишүүнчлэлээс гарах асуудлыг тусгасан;
3. Удирдах Зөвлөлийн гишүүдийн идэвхи, оролцоог нэмэгдүүлэхийн тулд бүх гишүүдийн ээлжит хурлыг жил тутам хийдэг байх, уг хурлаар Удирдах зөвлөлийн гишүүдийн 1/3-ийг өөрчлөхөөр тусгасан;
4. Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хороодод нэр дэвшүүлэн хамгийн их санал авсан 15 хүнийг сонгох эсвэл квотоор сонгууль явуулан хамгийн их санал авсан 15 хүнийг квотын төлөөллийг харгалзан сонгох гэсэн хоёр хувилбараар явуулахыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэх;
5. Хуулиар үнэлгээний үйл ажиллагааг аж ахуйн нэгжийн хэлбэрээр явуулж болохоор заасны дагуу хэд хэдэн үнэлгээчин нэгдэн компани хэлбэрээр явуулж ирсэн. Иймд үнэлгээний компанийн хангасан байх шалгуур үзүүлэлтүүдийг нэмж тусгасан.

Хүндэтгэсэн,

Б.ЭНХБОЛД,

Ажлын хэсгийн ахлагч

Тэргүүлэх үнэлгээчин,

Мэргэжлийн Хариуцлагын хорооны дарга